



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУЦААЛ

2016 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

Г Далайн захиргааны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дүгээр заалт, “Далай ашиглах” тухай хуулийн 8¹ дугаар зүйлийн 1¹ дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Далайн захиргааны бүтэц зохион байгуулалт, орон тоог нэгдүгээр хавсралтаар, дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 55 дугаар тушаалын 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



Далайн захирагааны дарга (1)

Дотоодын хууль тогтоомж, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн - 1	Дотоодын хууль тогтоомж, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн - 1
ОУ-ын тэрээ эрх зүй хариуцсан мэргэжилтэн - 1	ОУ-ын тэрээ эрх зүй хариуцсан мэргэжилтэн - 1
Бичиг хэрэг болон ахив хариуцсан мэргэжилтэн. нярав - 1	Бичиг хэрэг болон ахив хариуцсан мэргэжилтэн. нярав - 1

Захиргаа удирдлагын хэлтсийн дарга (1)

Няглан бодох буртгэл хариуцсан мэргэжилтэн - 1
--

Хөлөг онгоцын буртгэл, хяналтын алба

Усан замын тээврийн буртгэл хариуцсан мэргэжилтэн - 1

Дотоодын усан замын тээврийн буртгэл, хяналтын алба	Дотоодын хууль тогтоомж, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн - 1
Хяналтын усын байцаач - 3 (Унээс 1 нь ахлах)	Хяналтын усын байцаач - 3 (Унээс 1 нь ахлах)
Үйл ажиллагааны чиглэл	Үйл ажиллагааны чиглэл
Далайн тээвэр, логистик хариуцсан мэргэжилтэн - 2	Далайн тээврийн стратеги төвлөлт
Боомт ашиглалт хариуцсан мэргэжилтэн - 2	Бодлогын хэрэгжилтийг зохицуулалт
Далбаны эзэн улсын хянан шалтагч - 3	Олон улсын талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтэд хянант тавих
Хөлөг онгоцын буртгэлтэй холбоотой дүрэм, журам боловсронуй болгох	Зааварчилгаа, зохицуулалт
Хөлөг онгоцын буртгэлтэй холбоотой дүрэм, журам боловсронуй болгох	Далайн олон улсын талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг зохицуулалт
Хөлөг онгоцын нийтэлэгүүдийн үйл ажиллагаанд хянант тавих	Олон улсын гэрээ, хэлэлцэр, конвенцийг судлах, удирдлагыг мэдээлэлээр хангах
Хөлөг онгоц тусламжийн харилцах	Усан замын тээврийн хэрэгслийн буртгэл
Хөлөг онгоц тусламжийн харилцах	Болон тэдээрт хэрэгжүүлэх замналын судалгаа хийх, мэдээлэлээр хангах
Хөлөг онгоц тусламжийн харилцах	Олон улсын гэрээ, хэлэлцэр, конвенцийг судлах, удирдлагыг мэдээлэлээр хангах
Хөлөг онгоц тусламжийн харилцах	Боомт ашиглалтын хөнгөлөлтэй нөхцөлийг тохиролцож чиглэлээр ажилласан

Үйл ажиллагааны чиглэл	Үйл ажиллагааны чиглэл
Далайн тээврийн стратеги төвлөлт	Дотоодын усан замын тээврийн нэгдсэн зохицуулалт
• Бодлогын хэрэгжилтийг зохицуулах,	• Бодлогын хэрэгжилтийг зохицуулах,
• Олон улсын талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтэд хянант тавих	зохицуулах, хэрэгжүүлэх
• Гэрчилгээ опготын хянант шалтгалаат	Хууль тогтоомжийн хэрэгжилт
• Агенттуудын болон ангуялтын нийтэлэгүүдийн үйл ажиллагаанд хянант тавих	• Олон улсын гэрээ, хэлэлцэр, конвенцийг судлах, удирдлагыг мэдээлэлээр хангах
• Эргийн хянант, анилтын нийтэлэгүүдий харилцах	• Усан замын тээврийн хэрэгслийн буртгэл
• Хөлөг онгоц тусламжийн харилцах	• Далайн тээвэр эрхлэх судлах боломжийг судлах, удирдлагыг мэдээлэлээр хангах
• Хөлөг онгоц тусламжийн харилцах	• Олон улсын гэрээ, хэлэлцэр, конвенцийг судлах, удирдлагыг мэдээлэлээр хангах

Үйл ажиллагааны чиглэл	Үйл ажиллагааны чиглэл
Буртгэлтэй холбоогийн чиглэл	Буртгэлтэй холбоогийн чиглэл
Хөлөг онгоцын буртгэлтэй холбоогийн чиглэл	Хөлөг онгоцын буртгэлтэй холбоогийн чиглэл
Хөлөг онгоц тусламжийн буртгэлтэй холбоогийн чиглэл	Хөлөг онгоц тусламжийн буртгэлтэй холбоогийн чиглэл
Хөлөг онгоц тусламжийн буртгэлтэй холбоогийн чиглэл	Хөлөг онгоц тусламжийн буртгэлтэй холбоогийн чиглэл

Үйл ажиллагааны чиглэл	Үйл ажиллагааны чиглэл
Буртгэлтэй холбоогийн чиглэл	Буртгэлтэй холбоогийн чиглэл
Хөлөг онгоц тусламжийн буртгэлтэй холбоогийн чиглэл	Хөлөг онгоц тусламжийн буртгэлтэй холбоогийн чиглэл
Хөлөг онгоц тусламжийн буртгэлтэй холбоогийн чиглэл	Хөлөг онгоц тусламжийн буртгэлтэй холбоогийн чиглэл
Хөлөг онгоц тусламжийн буртгэлтэй холбоогийн чиглэл	Хөлөг онгоц тусламжийн буртгэлтэй холбоогийн чиглэл

Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2016 оны
12 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот
тушаалтын 2 дугаар хавсралт

УХА0382
5919487
1116126781

**МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ
ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрэм нь Монгол Улсын Далайн захиргаа /цаашид "Далайн захиргаа" гэх/-ны бүтэц зохион байгуулалт, орон тоо, ажиллах журам, эрх үүргийн зохицуулалтыг тодорхойлно.

1.2. Далайн захиргаа нь Монгол Улсын далайн болон усан замын тээврийн салбарын бодлого, хөтөлбөр, төслийг холбогдох хууль, тогтоомж, олон улсын гэрээ, конвенци, дүрэм, журам, стандарт, зөвлөмжид нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн байгууллага, албан газар болно.

1.3. Далайн захиргаа нь тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд түүнээс өгсөн чиглэл, удирдамжийн дагуу үйл ажиллагаагаа явуулж, ажлаа түүнд тайлагнана.

1.4. Далайн захиргаа нь билэгдэлтэй байх бөгөөд гадаад, дотоод албан бичгийн хэвлэмэл хуудас, тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг хэрэглэнэ.

Хоёр. Далайн захиргааны бүтэц, зохион байгуулалт

2.1. Далайн захиргаа нь Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, далайн болон усан замын тээврийн аюулгүй байдлыг хангах, хяналт тавихад чиглэсэн эрх, үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц, орон тоотой байна.

2.2. Далайн захиргааны удирдлагыг томилох, бүтэц, зохион байгуулалт, орон тоо, дүрмийг батлах асуудлыг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

2.3. Далайн захиргаа нь үйл ажиллагаагаа дараах үндсэн салбар чиглэлээр хэрэгжүүлнэ. Үүнд:

- дотоодын усан замын тээвэр,
- Монголын хөлөг онгоцны бүртгэл,
- далайн боомт ашиглалт,
- далайн тээвэр.

2.4. Далайн захиргааны дарга Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль, Усан замын тээврийн тухай хууль, Далай ашиглах тухай хууль, Хөдөлмөрийн тухай

хууль, Төсвийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү дүрэм, байгууллагын дотоод журамд нийцүүлэн өөрийн бүрэн эрхийн хүрээнд тушаал гаргана.

Гурав. Далайн захиргааны үйл ажиллагааны үндсэн зарчим

3.1. Далайн захиргаа нь өөрийн үйл ажиллагаандаа Далай ашиглах тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль, олон улсын далайн эрх зүйн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, олон улсын эрх бүхий байгууллагаас өгсөн удирдамж, заавар, гадаад улс орнуудтай далайн салбарт байгуулсан гэрээ, хэлэлцээр, УИХ, Засгийн газрын бодлого, шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөр, "Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам" болон бусад холбогдох хууль, тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

3.2. Далайн захиргааны үйл ажиллагааны үндсэн зорилго нь Монгол Улсын хууль, тогтоомж, далайн салбарын олон улсын гэрээ, конвенцийн хэм хэмжээнд нийцүүлэн далайн болон усан замын тээврийн аюулгүй байдлыг хангах, хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хөлөг онгоцны бүртгэл, дотоодын усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, үзлэг оношлогооны үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханганд хэрэгжүүлж ажиллахад оршино.

Дөрөв. Далайн захиргааны чиг үүрэг

4.1. Далайн захиргаа нь далайн салбарын холбогдох хууль болон Монгол Улсын нэгдэн орсон далайн салбарын олон улсын гэрээний дагуу дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:


4.1.1. далайн болон усан замын тээврийн стратеги, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжүүлэх, хяналт тавих, энэ чиглэлийн мэдээллээр удирдлагыг хангах;

4.1.2. далайн салбарын чиглэлээр дотоод, гадаадын холбогдох байгууллагуудтай хамтарсан сургалт зохион байгуулах, үндэсний мэргэжилтэн бэлтгэх, мэргэжилтэй ажилтан сургах, давтан сургах, мэргэшүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

4.1.3. Монгол Улсын далайчны үнэмлэхийг гадаад улсын эрх бүхий байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэх;

4.1.4. далайн салбарын олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох, соёрхон батлах хуулийн төсөл боловсруулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, хэрэгжүүлэх;

4.1.5. хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүнд ажиллах үндэсний боловсон хүчний ойрын болон хэтийн хэрэгцээг тодорхойлох, түүнийг олон улсын зохих гэрээнд нийцүүлэх ажлын бэлтгэлийг хангах, зохион байгуулах;



4.1.6. далайн болон усан замын тээврийн салбарын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, мэргэжлийн түвшинд хяналт тавих (мэргэжлийн байцаагч ажиллуулах), удирдлагыг энэ чиглэлийн мэдээллээр хангах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.1.7. далайн салбарын эрх зүйн* орчныг боловсронгуй болгох, олон улсын конвенцид нэгдэн орох тухай санал гаргах;

4.1.8. Олон улсын далайн байгууллага (ОУДБ)-аас гаргасан зөвлөмжийг үйл ажиллагаандaa удирдамж болгон ажиллах, удирдлагыг энэ чиглэлийн мэдээллээр цаг тухайд нь хангах;

4.1.9. Олон улсын далайн байгууллага (ОУДБ) болон бусад олон улсын байгууллагуудтай бодлогын хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, олон улсын гэрээ, конвенцоор тогтоосон хэм хэмжээ, мөрдөгдөж буй стандарт, дүрэм, журам, удирдамжийн дагуу хамтран ажиллаж, Монгол Улсын эрх ашигт нийцсэн санал боловсруулж, холбогдох яам болон байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

4.1.10. Олон улсын далайн байгууллага (ОУДБ) болон бусад холбогдох байгууллагаас зохион байгуулж буй хурал, зөвлөгөөн, семинарт оролцох, түүнээс гарах шийдвэрт санал боловсруулах, шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

4.1.11. далайн салбарт орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, шинжлэх ухаан, технологийн судалгаа шинжилгээний ажлын хөтөлбөр боловсруулахад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах;


4.1.12. хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;

4.1.13. хүний нөөцийн бодлого, хөтөлбөр боловсруулах, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

4.1.14. бүтцийн нэгжийн даргыг томилж, чөлөөлөхөд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газартай зөвшилцэж шийдвэрлэх;

4.1.15. далайн болон усан замын тээврийн салбарт хөрөнгө оруулах нөхцөл боломжийг бүрдүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжих, батлагдсан төсвийг захирсан зарцуулах;

4.1.16. далайн болон усан замын тээврийн үйл ажиллагаа эрхлэх өмчийн бүх хэлбэрийн байгууллагуудад мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, ажилтнуудыг мэргэжлийн сургалтад хамруулах,



хамрагдах боломжийг бүрдүүлэх, уг асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулах;

4.1.17. хариуцсан ажлын чиглэлээр шаардлагатай тохиолдолд дүгнэлт гаргах, магадлан шинжилгээ хийлгэх зэрэг тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор гадаад, дотоодын шинжээч, мэргэжилтэн болон бусад ажилтныг гэрээний үндсэн дээр татан оролцуулах, тэдгээрт цалин, урамшуулалт олгох асуудлыг шийдвэрлэх;

4.1.18. далай болон гол мөрөнд усан замын тээвэр хийх, хөлөг онгоцны бүртгэл явуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлох, төлөвлөгөө, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх;

4.1.19. далайн болон усан замын тээврийн асуудлаар төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн хоорондын мэдээлэл солилцоог сайжруулах, тухайн асуудлаар шийдвэр гаргахад оролцох, санал боловсруулах;

4.1.20. Олон улсын далайн байгууллага (ОУДБ)-тай Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаараа дамжуулж, бусад ижил төстэй гадаадын байгууллага, гадаад орнуудын далайн захиргаатай шууд харьцах замаар хамтран ажиллаж, туршлага судлах, үндэсний мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх асуудлыг эдгээр байгууллагуудад тавьж, сургах, дадлагажуулах арга хэмжээ авах, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх хамтарсан сургалтыг зохион байгуулах.


4.2. Далайн захиргаа нь хөлөг онгоц бүртгэх, гэрчилгээ олгох, хяналт тавих чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.2.1. Монголын хөлөг онгоцны бүртгэл эрхэлж буй хамтарсан компани болон гэрээт байгууллагуудын хамтын ажиллагааны гэрээ, холбогдох дүрэм, журмыг мөрдүүлэх,

4.2.2. хамтарсан компанийн гүйцэтгэх удирдлага болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох, чөлөөлөх асуудлаар далайн болон усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөх, шаардлагатай тохиолдолд дээрх байгууллагуудад санхүүгийн хяналт, шалгалт хийх, аудиторыг сонгон гэрээгээр ажиллуулах асуудлыг зохицуулах;

4.2.3. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журмын дагуу бүртгэлийн түр болон байнгын гэрчилгээ олгох;

4.2.4. хөлөг онгоц дангаар түрээслэх гэрээний маягт, хөлөг онгоцны байнгын болон түр гэрчилгээний загвар, техник хяналтын байгууллага, агенттai хийх гэрээний загвар, хөлөг онгоц бүртгэлийн тариф зэргийг боловсруулан тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах;



4.2.5. хөлөг онгоц бүртгэх төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө, санал өгөх, хэрэгжилтэд хяналт тавих, энэ чиглэлийн мэдээллээр удирдлагыг хангах;

4.2.6. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны тайлан, эдийн засгийн үзүүлэлтийн мэдээ, судалгааг сар, улирал, жилээр, тухай бүр гарган мэдээллийг нэгтгэн боловсруулж, санал дүгнэлт гаргах, яамны удирдлагыг энэ чиглэлийн мэдээллээр хангах;

4.2.7. хөлөг онгоцонд техникийн ү злэг, хяналт хийлгэх а суудлаар олон улсын холбогдох эрх бүхий мэргэжлийн байгууллагатай батлагдсан загварын дагуу гэрээ, хэлцэл байгуулах, зохицуулах, хэрэгжүүлэх;

4.2.8. бүртгэлтэй хөлөг онгоцны гаргасан зөрчлийн мэдээллийг тухай бүр авч, зөрчлийг арилгуулах ажлыг шуурхай зохион байгуулах, удирдлагыг энэ чиглэлийн мэдээллээр хангах;

4.2.9. хөлөг онгоцны бүртгэл, далбааны эзэн улсын хяналтын асуудлаар олон улсын холбогдох эрх бүхий мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах;

4.2.10. далай ашиглах үйл ажиллагаанд техник, технологийн шийдлийг (LRIT) ашиглан бүртгэлийн боомтоос хөлөг онгоцыг хянах, далайн тээврийн хөдөлгөөнт сүлжээний таних дугаар /Call sign. MMSI/ олгох, удирдлагыг энэ чиглэлийн мэдээллээр хангах, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

4.3. Далайн захиргаа нь далай, усан зам дахь хүний аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг бохирдлоос хамгаалах талаар хяналт тавих чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.3.1. далайн ба усан замын салбарын аюулгүй ажиллагааны бодлого, хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө, төслийн санал боловсруулж далай, усан замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах;

4.3.2. Олон улсын далайн байгууллага (ОУДБ) болон бусад холбогдох гадаадын байгууллагатай далайн болон усан замын салбарын аюулгүй ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах, шаардлагатай дүрэм, журам боловсруулах асуудлыг удирдах дээд байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх;

4.3.3. Удирдах дээд байгууллагаас боловсруулсан гадаад улс, тэдний боомтын хяналтын байгууллагатай далайн болон усан замын тээврийн салбарын аюулгүйн ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах, энэ чиглэлээр ажилтнуудаа туршлага судлуулах, давтан сургах, мэргэшүүлэх;



4.4. Далайн захиргаа нь дотоодын усан замын тээвэр, зохицуулалтын чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.4.1. усан замын салбарыг хөгжүүлэх ойрын болон хэтийн бодлого, хөтөлбөр, төслийг боловсруулахад санал оруулах, хэрэгжүүлэх талаар холбогдох яам, байгууллагуудтай хамтарч ажиллах, энэ чиглэлийн мэдээллээр удирдлагыг хангах;

4.4.2. усан замын тээврийн үйлчилгээний чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, дүрэм журам, норм, норматив, стандартын санал боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, энэ чиглэлийн мэдээллээр удирдлагыг хангах,

4.4.3. дотоодын усан замын тээврийн хэрэгслийг бүртгэх үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, батлагдсан дүрэм, журмын дагуу улсын нэгдсэн бүртгэлд хамруулах, бүртгэлээс хасах, тээврийн хэрэгсэл эзэмших гэрчилгээ олгох, цуцлах;

4.4.4. дотоодын усан замын тээврийг хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг тодорхойлох, төлөвлөгөө, төслийн санал боловсруулах, энэ чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авч ажиллах;

4.4.5. усан замын тээврийн хэрэгслийг осол зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хяналт, шалгалт зохион байгуулах, олон нийтэд сурталчлан таниулах;

4.4.6. усан замын тээврийн салбарын үйл ажиллагаанд дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлэх, шинжлэх ухаан, технологийн судалгаа, шинжилгээний ажлын хөтөлбөр, төсөл боловсруулах чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

4.4.7. усан замын тээврийн үйлчилгээг боловсронгуй болгох зорилгоор мэргэжлийн сургалт семинарыг зохион байгуулж, дотоодын усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигчдийг хамруулах, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх;

4.4.8. усан замын тээврийн тухай Монгол улсын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтарсан үзлэг шалгалт хийх;

4.4.9. усан замын тээврийн салбарын үйл ажиллагааны тайлан, эдийн засгийн үзүүлэлтийн мэдээ, судалгааг авч нэгтгэх, санал дүгнэлт гаргах.

4.5. Далайн захиргаа нь далайн тээвэр, боомт ашиглалтын чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.5.1. далайн болон усан замын тээврийн салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах;

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ЭХ ХУВЬ

4.5.2. далайн тээвэрлэлтэд оролцоход гарч болох хүндрэл бэрхшээлийг судлан шийдвэрлүүлэх, санал боловсруулах;

4.5.3. далайн тээврийн компанийг үр ашигтай ажиллуулах зорилгоор үйл ажиллагаанд нь хяналт тавьж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, уул уурхай, тээвэр зууч, төмөр зам болон бусад логистикийн сүлжээнд оролцогч талуудтай хамтран ажиллах, тэдэнд дэмжлэг үзүүлэх;

4.5.4. далайн тээврийн үйл ажиллагааг олон улсын стандарт хэм хэмжээ болон хүний амь нас, эд хөрөнгө эрсдэхээс хамгаалах, байгаль орчныг бохирдуулахын эсрэг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн явуулахад анхаарч зохих хяналтыг тавих, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажлыг зохиог байгуулах;

4.5.5. далайн тээврийн салбар дахь хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог дэмжиж мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

4.5.6. хөрш зэргэлдээ болон бусад гуравдагч орны нутаг дэвсгэрт байрлах, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй, найдвартай, тогтвортой ажиллах далайн боомтуудын судалгааг гаргах, тэдэнтэй хамтран ажиллах;

4.5.7. бусад орны далайн боомтод төлөөлөгчийн газар нээн ажиллуулах талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

4.5.8. судалгаа бүхий боомтуудыг Монгол Улсад ашигтай нөхцөлөөр ашиглах боломжийн талаар санал дэвшүүлэх, төсөл боловсруулж төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, шийдвэрлүүлэх;

4.5.9. Засгийн газар болон яамдын хооронд байгуулагдсан боомт ашиглах тухай гэрээ, хэлэлцээр, санамж бичигт тусгагдсан зүйл заалтыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

4.5.10. далайн тээвэр, логистик, боомт ашиглалтын чиглэлээр мэргэжил эзэмшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхийг сайжруулах.

Тав. Далайн захиргааны санхүүжилт

5.1. Далайн захиргааны жил бүрийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хянаж батална.

5.2. Далайн захиргаа нь Далай ашиглах тухай хуульд заасны дагуу үйл ажиллагааны орлого болон улсын төсвөөс санхүүжинэ.

5.3. Үйл ажиллагааны орлого болон батлагдсан төсвийг Далайн захиргааны дансанд төвлөрүүлэн Далайн захиргааны дарга нь батлагдсан төсвийн хүрээнд хөрөнгө, санхүүг зарцуулна.

Зургаа. Бусад



6.1. Энэхүү дүрэм нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нэмэлт, өөрчлөлт оруулж, хүчингүй болгоно.

----Оо----

